

**ХИЛ ХАМГААЛАХ
БАЙГУУЛЛАГЫН АЛБА
ХААГЧ НЭГ БҮРИЙН
ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ
ХЭРЭГЛЭХ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТАД ХИЙСЭН
ДҮН ШИНЖИЛГЭЭ**

С.Нямжав

*Тактикийн тэнхимийн эрхлэгч,
цагдаагийн дэд хурандаа*

Товч агуулга: Хил хамгаалах байгууллагын алба хаагчид хуулиар хүлээсэн чиг үүргийг биелүүлэхдээ холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэлийн дагуу нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх эрхийг дотоодын хууль тогтоомжоор олгосон байна. Энэхүү хууль тогтоомжид тусгагдсан нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан хэм хэмжээг өөр хооронд болон нь төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий зарим байгууллагын холбогдох эрх зүйн актад тусгасан хэм хэмжээтэй харьцуулан зүйн эрх зүйн зохицуулалтад байгаа онол, практикийн зөрчилтэй тулгамдаж буй асуудлыг олж, тодорхойлохыг зорьж, түүнийг

шийдвэрлэх
боловсруулсан.

саналыг

Түлхүүр үг: хилчин, тусгай хэрэгсэл, нэг бүрийн тусгай хэрэгсэл, хууль, хуульчилсан акт, эрх зүйн зохицуулалт

Үндсэн хэсэг. Монгол Улсад нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх эрх бүхий нийт 15 субъект байна. Үүнийг нэг нь хил хамгаалах байгууллагын алба хаагч юм. Монгол Улсын хилийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын хил хамгаалах үйл ажиллагаанд нисдэг тэрэг, хуягт тээвэрлэгч, газар, уснаа явагч зэрэг тусгай хэрэгслээр тоноглогдсон тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгсэл албадан зогсоогч, эвдэгч, галт хэрэглэл, албаны нохой болон бусад тусгай хэрэгсэл ашиглаж болно”¹ гэж хил хамгаалах байгууллагын алба хаагчид нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх эрхийг хуулиар олгож, мөн үүргийн хэм хэмжээг уг хуулиар зааж өгсний зэрэгцээ, “Хил хамгаалах байгууллагын алба хаагч тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх”² заавар, “Хил хамгаалах байгууллагын галт зэвсэгтэй

¹ Монгол Улсын хилийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2017 он. №6.

² Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/160 дугаар тушаал

адилтгах үхэлд үл хүргэх зэвсэг, тусгай хэрэгслийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилт”¹-ийн заавар зэрэг хадгалах, ашиглах, хэрэглэх арга зүй, тактикийн шинжтэй хэм хэмжээг тус тус хуульчилсан актаар зохицуулж, өгсөн байна.

Энэхүү илтгэлээр Хил хамгаалах байгууллагын алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан хууль, хуульчилсан актыг өөр хооронд нь болон төрийн тусгай чиг үүрэг гүйцэтгэдэг цагдаа, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын холбогдох хуульчилсан актын зарим заалтын хэм хэмжээтэй харьцуулалт хийв.

Судалгаагаар хил хамгаалах байгууллагын алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтад онол, практикийн хувьд зөрчилтэй дараах асуудлууд байна гэж үзлээ. Үүнд:

Нэг. Хууль, хуульчилсан актад нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрхэн төрөлжүүлсэн талаар

1. Хил хамгаалах байгууллагын алба хаагч үүргээ гүйцэтгэхдээ ашиглах нэг бүрийн тусгай хэрэгслийг холбогдох хууль, хуульчилсан актад дараах байдлаар төрөлжүүлжээ. (Хүснэгт №1)

№	Монгол Улсын хилийн тухай хууль	Заавар
1.	42.1 дэх хэсэгт Нэг бүрийн тусгай хэрэгсэлд дараах хэрэгсэл хамаарна: 1) Гав; 2) Хүлэг, ороох цамц, хөдөлгөөн хязгаарлах бусад хэрэгсэл; 3) Бороохой; 4) Цахилгаан гүйдлээр цохигч; 5) Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;	3.9.2-т “Цахилгаан гүйдлээр цохигч бууг хүний биед 4-5 метрийн зайд хэрэглэх бөгөөд нэг газар 3 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар байрлалыг сольж, амьтанд 5 секундээс илүүгүй хугацаагаар хэрэглэнэ”, 3.10.1-т “Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүрийг барилга, байгууламж дотор тухайн бодисын үйлчлэлд өөрөө өртөхгүй байрлалд, гадна орчинд салхины дагуу чиглэлд цацах, гранат хэлбэрээр шидэх,

¹ Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/09 дүгээр тушаал

6) Резин ба хуванцар сумтай буу; 7) Нэг бүрийн бусад тусгай хэрэгсэл.	буудлагын хэрэгслээр буудах зэргээр хэрэглэнэ” гэж заасан.
--	--

Хүснэгт 1. Холбогдох хууль, хуульчилсан актад төрөлжүүлсэн байдал

Энэхүү хууль, хуульчилсан актад төрөлжүүлсэн байдалд харьцуулалт хийхэд:

- Монгол Улсын хилийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.5 дахь заалтад “нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;”¹ гэж заасан нь гар бөмбөг буюу гранат хэрэглэхгүй зөвхөн буу, шүршүүр хэрэглэхээр тусгасан. Гэтэл “Хил хамгаалах байгууллагын алба хаагч тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар”²-ын 3.10.1 дэх хэсэгт “Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүрийг ... цацах, гранат хэлбэрээр шидэх, буудлагын хэрэгслээр буудах зэргээр хэрэглэнэ.” хэрэглэнэ гэж заасан нь гар бөмбөгийг нэг бүрийн тусгай хэрэгсэлд хамааруулж, ойлгохоор тусгасан байна. Энэ нь хууль эрх зүйн актад харилцан адилгүй алба хаагчийн хэрэглэх амьсгал боогдуулагч, нулимс асгаруулагчаар цэнэглэсэн гар

бөмбөгийг ямар төрлийн хэрэгсэлд оруулан тооцох нь тодорхой бус тусгасан гэж үзэж байна.

- Монгол Улсын хилийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1. дэх хэсэгт нийт 7 төрлийн хэрэгслийг хэрэглэхээ заасан бөгөөд эдгээр хэрэгсэлд цахилгаан гүйдлээр цохигч гэсэн хэрэгсэл хэрэглэхээр тусгаагүй. Харин “Хил хамгаалах байгууллагын алба хаагч тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх”³ зааврын 3.9.2 дахь хэсэгт **“Цахилгаан гүйдлээр цохигч бууг** хүний биед 4-5 метрийн зайд хэрэглэх бөгөөд нэг газар 3 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар байрлалыг сольж, амьтанд 5 секундээс илүүгүй хугацаагаар хэрэглэнэ” гэж заасан нь дахин заавраар цахилгаан гүйдлээр цохигч буу гэсэн нэг бүрийн тусгай хэрэгслийг нэмэлтээр оруулж ирсэн. Энэ нь хуульд тусгагдаагүй хэрэгслийг заавраар зохицуулж,

¹ Монгол Улсын хилийн тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2017 он. №6.

² Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/160 дугаар тушаал

³ Мөн тэнд

хэрэглэхээр заасан. Эдгээр хууль болон заавар, журамд тусгагдсан байдлаас харахад хэдэн төрөл, ангилалд авч үзэж, ямар хэрэгсэлд хамаарах нь тодорхой бус ойлгомжгүй байгааг харуулж байна.

Хоёр. Хэрэглэх тохиолдлыг хууль, хуульчилсан актад хэрхэн зохицуулсан талаар

Хил хамгаалах байгууллагын алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан хууль, хуульчилсан актад тусгагдсан хэрэглэх тохиолдолд харьцуулалтыг хийлээ. (Хүснэгт №2)

№	Монгол Улсын хилийн тухай хууль	Заавар
1.	43 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хилчин нэг бүрийн тусгай хэрэгслийг дараах тохиолдолд хэрэглэнэ: 1) Өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болох аюулыг таслан зогсоох; 2) Хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг таслан зогсоох, зөрчил гаргасан этгээдийг саатуулах, баривчлах; 3) Зэвсэглэсэн болон зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй хүнийг баривчлах; 4) Баривчлагдсан, саатуулагдсан хүнийг хуяглан хүргэх; 5) Хяналтад байгаа хүн амиа хорлох, өөрийн бие махбодод гэмтэл учруулах, оргон зайлахаас урьдчилан сэргийлэх зорилгоор; 6) Сэтгэцийн эмгэг, сэтгэл санаа хүчтэй цочрон давчидсаны улмаас өөрийгөө удирдах чадваргүй, түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн, эсхүл догшин, хэрцгий авирлаж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаар бол; 7) Тээврийн хэрэгслийг зогсоох эрх бүхий албан тушаалтны шаардлагыг үл биелүүлэн зугтаасан;	Зааврын 3.7-д “Хуульд заасан үндэслэлээр бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалахын тулд, эсхүл сэжигтэй этгээдийг аюул учруулахгүйгээр хяналтад авахад биеийн хүч хэрэглэх боломжгүй тохиолдолд резинэн бороохой, цахилгаан гүйдлээр цохигч, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр, резинэн ба хуванцар сумтай бууг сонгон хэрэглэж болно” гэж заасан.

	8) Энэ хуульд галт зэвсэг хэрэглэхээр заасан тохиолдолд” гэж заасан. 43 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг хилчин тухайн нөхцөл байдалд тохируулан бие даан гаргана” гэж заасан.	
2.	43 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хилчин доор дурдсанаас бусад тохиолдолд хүүхэд, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай, бэртэл гэмтэлтэй болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүнд нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно: 1) Хилчин болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар зэвсэглэн, эсхүл бүлэглэн довтолсон; 2) Галт зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох зүйлээр зэвсэглэсэн хүн зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлсэн, эсэргүүцсэн; 3) Амиа хорлож болзошгүй бол” гэж заасан.	Зааврын 3.8.3-т “Хилийн болон хил орчмын дэглэмийг бүлэглэн зөрчиж байгаа, эсхүл хилийн боомтод үүссэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хүч хэрэглэсэн жагсаал, цуглааныг албадан тараах, довтолсноос бусад тохиолдолд хүний толгой, давсаг, бүсэлхий, бөөр, нэг газарт олон удаа цохих, гэмтэл, шарх үүсгэхийг хориглоно” гэж заасан. 3.11.2-т “Резинэн ба хуванцар сумтай бууг хүний биеийн цээж, нуруу, гар, хөл, гуяны хэсэгт хэрэглэх бөгөөд нүүр, толгой /ил харагдах хэсэг/-н хэсэгт хэрэглэхийг хориглоно” гэж заасан.

Хүснэгт 2. Холбогдох хууль, хуульчилсан актад тусгасан хэрэглэх тохиолдол

Энэхүү хууль, хуульчилсан актад хэрэглэх тохиолдолд хийсэн харьцуулалтаас үзвэл:

- Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Монгол Улсын хилийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт нийт 8 тохиолдолд хэрэглэхээр, “Хил хамгаалах байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх заавар”-аар 3 тохиолдолд хэрэглэхээр тус тус эрхийг алба хаагчид олгосон боловч, мөн хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэгт “Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг хилчин тухайн нөхцөл байдалд тохируулан бие даан гаргахаар” тухайн хуульд тусгаж өгсөн нь

ямар тохиолдолд аль хэрэгслийг нь хэрэглэх талаар тодорхой бус байгаа бөгөөд гэж ерөнхий заалтыг тусгасан;

- Хил хамгаалах байгууллагын алба хаагч тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх зааврын 3.7 дахь хэсэг, 3.8.3 дахь хэсэг, 3.11.2 дахь хэсэгт тус тус заасан хэм хэмжээ нь нэмэлтээр хэрэглэх болон хориглох тохиолдлыг дахин хуулиас гадна хуульчилсан актад тус тус тусгаж, зохицуулсан;

Монгол Улсын хилийн тухай хуульд 8, "Хил хамгаалах байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх заавар"-т 3, нийт 11 тохиолдолд хэрэглэх, мөн хуулийн 1 заалтад, зааврын 2 заалтад тус тус хориглосон хэм хэмжээг тусгаж, эрх зүйн харилцааг зохицуулжээ.

Ийнхүү заавраар 1 заалтад 3 тохиолдолд хэрэглэхээр, мөн 2 заалтад тус бүр 1 хориглох тохиолдлыг тусгаж, хуулиас гадна хуульчилсан актаар хэм хэмжээг тогтоож, зохицуулсан байдал нь "Хууль цаазын дээд хүчин чадал нь дараах шинжээр тодорхойлогдоно: ... б) эрх зүйн бусад актууд нь зөвхөн хуульд захирагдаж, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ"¹, "яам засгийн газрын гишүүд, агентлаг, тусгай газрын дарга нар нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, шийдвэрт нийцсэн, эрх зүйн хэм хэмжээг агуулсан актуудыг батлан гаргана"² гэж тус тус эрдэмтэн, судлаачид онолын хувьд үздэг. Гэтэл харьцуулалтаас үзвэл заавар нь Монгол Улсын хилийн тухай хууль заасан хэм хэмжээнд нийцэж, захирагдахгүй дахин нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх хэм хэмжээг тусгасан нь хууль цаазын дээд хүчин чадал, шатлан захирах шинж алдагдсан гэж үзэж байна.

Гурав. Нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх арга, үүрэг, шаардлагыг хуульчилсан актад хэрхэн тусгасан талаар

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий 4 агентлаг, байгууллагуудын заавар, журмуудын нэршил болон нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрхэн хэрэглэх талаарх холбогдох заалтуудад харьцуулалтыг хийлээ. (Хүснэгт №3)

№	Хил хамгаалах байгууллага	Дотоодын цэрэг	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага	Цагдаа
---	---------------------------	----------------	---------------------------------------	--------

¹ Ч.Нямсүрэн, Ч. Эрх зүйн ерөнхий онол. УБ., 2017. 183 дахь тал

² Мөн тэнд., 2017. 175 дахь тал

Хуульчилсан актын нэр				
1.	“Хил хамгаалах байгууллагын алба хаагч тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх” ¹ заавар	“Дотоодын цэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд хэрэглэх тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техникийг хэрэглэх” ² заавар	“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх” ³ журам	“Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх” ⁴ заавар
Нэг. Бороохой хэрэглэх талаар				
1.	-Бороохойг хувцастай болон нүцгэн биед чиглүүлж ороолгох маягаар цохих, хатгах, бамбай, бусад эд зүйлд цохиж, дуу чимээ гаргах, зэвсгийн чанартай эд зүйлээр довтолсон тохиолдолд хамгаалах зорилгоор өгзөгний маханд буюу дал хавсарч хэрэглэх	-Бороохойг хувцастай болон нүцгэн биед чиглүүлж ороолгох маягаар цохих, хатгах болон бамбай, бусад эд зүйлд цохиж, дуу чимээ гаргах, зэвсгийн чанартай эд зүйлээр довтолсон тохиолдолд хамгаалах зэргээр хэрэглэх	-Хүний биеийн яс булчин дагуу ороолгох, цохих, хатгах байдлаар үйлдлийг таслан зогсоох	-Бороохойг хүний хувцастай болон нүцгэн биеийн яс, булчин дагуу чиглүүлж ороолгох, цохих, хатгах бамбай, бусад эд зүйлд цохиж, дуу чимээ гаргах, зэвсгийн чанартай эд зүйлээр довтолсон тохиолдолд хамгаалах

¹ Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан 2017 оны 06-аар сарын 09-ний өдрийн А/160 дугаар тушаал

² Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 04-ээр сарын 03-ны өдрийн А/57 дугаар тушаал

³ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2017 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/260, А/112 дугаар тушаал

⁴ Хууль зүй, дотоод хэргийн сйн сайдын 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/160 дугаар тушаал

⁴ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/57 дугаар тушаал

⁴ Хууль зүй, дотоод хэргийн сайдайд, Улсын ерөнхий прокурорын хамтарсан 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/224, А/102 дугаар тушаал

				зэргээр хэрэглэх;
2.	-Хилийн болон хил орчмын дэглэмийг бүлэглэн зөрчиж байгаа, эсхүл хилийн боомтод үүссэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хүч хэрэглэсэн жагсаал, цуглааныг албадан тараах, довтолсноос бусад тохиолдолд хүний толгой, давсаг, бүсэлхий, бөөр, нэг газарт олон удаа цохих, гэмтэл, шарх үүсгэхийг хориглоно	-Бороохойгоор нэг газарт олон удаа цохихгүй, аль болох гэмтэл учруулахгүй байхыг эрмэлзэх	-Нэг газарт олон удаа цохихгүй байх, аль болох гэмтэл учруулахгүй байхыг эрмэлзэх	-Бороохойгоор нэг газарт олон удаа цохихгүй байх, аль болох гэмтэл учруулахгүй байхыг эрмэлзэх
Хоёр. Цахилгаан гүйдлээр цохигч, цахилгаан гүйдлээр цохигч буу хэрэглэх талаар				
3.	-Цахилгаан гүйдлээр цохигчийг хүний биед хувцасны гадна талаас хүргэн, долгион нэг газар 5 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар байрлалыг сольж, амьтанд 10 секундээс илүүгүй хугацаагаар хэрэглэнэ	-Цахилгаан гүйдлээр цохигчийг хэрэглэх зорилгыг хууль заасан үндэслэлээр тодорхойлж, хүний биед хувцасны гадна талаас хүргэн долгион нэг газар 5 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар	-Хувцасны гадна талаас хүргэн цахилгаан хүчдэлийг нэг байрлалд 10 секундээс илүүгүй хугацаагаар үйлчлэхээр хүргэж үйлдлийг таслан зогсоох;	-Цагдаагийн алба хаагч цахилгаан гүйдлээр цохигч хэрэглэх зорилгоо тодорхойлж, хүний биед хувцасны гадна талаас цахилгаан үелзлийг нэг газарт 5 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар хүргэн,

		байрлалыг сольж хэрэглэх бөгөөд энэ хугацаа нь араатан амьтанд 10 секундээс илүүгүй байхаар тооцох		байрлалыг сольж хэрэглэх ба энэ хугацаа нь араатан амьтанд 10 секундээс илүүгүй байхаар тооцох
4.	-Цахилгаан гүйдлээр цохигч бууг хүний биед 4-5 метрийн зайд хэрэглэх бөгөөд нэг газар 3 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар байрлалыг сольж, амьтанд 5 секундээс илүүгүй хугацаагаар хэрэглэнэ.	3.9.5.цахилгаан гүйдлээр цохигч бууг хэрэглэх зорилгыг хууль заасан үндэслэлээр тодорхойлж, 4-5 метрийн зайд байгаа биологийн объект /хүн, амьтан/-д чиглүүлэн хэрэглэх бөгөөд хүнд нэг газар 3 секундээс илүүгүй, араатан амьтанд 5 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар тооцож, байрлалыг солих	Байхгүй	-Цагдаагийн алба хаагч цахилгаан гүйдлээр цохигч бууг хэрэглэх зорилгоо тодорхойлж, цахилгаан гүйдлээр цохигч бууг 4-5 метрийн зайд байгаа хүний биед хэрэглэх бөгөөд нэг газар 3 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар чиглүүлэн, байрлалыг сольж хэрэглэх ба энэ хугацаа нь араатан амьтанд 5 секундээс илүүгүй байхаар тооцох
Гурав. Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр хэрэглэх талаар				
5.	-Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүрийг барилга,	-Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч ... буу, шүршүүрийг дараах	-Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийг салхины чиглэл дагуу 1-1,5 метрээс	-Цагдаагийн алба хаагч нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийг хэрэглэх

	байгууламж дотор тухайн бодисын үйлчлэлд өөрөө өртөхгүй байрлалд, гадна орчинд салхины дагуу чиглэлд цацах, гранат хэлбэрээр шидэх, буудлагын хэрэгслээр буудах	байдлаар хэрэглэнэ: 3.10.1.хуульд заасан үндэслэлээр хэрэглэх зорилгыг тодорхойлж, барилга, байгууламж дотор тухайн бодисын үйлчлэлд өөрөө өртөхгүй байрлалыг сонгох бөгөөд гадна орчинд салхины дагуу чиглэлд цацах, гранат хэлбэрээр шидэх, буудлагын хэрэгслээр буудах	дээш зайд цацах, шүрших, буудах	зорилгоо тодорхойлж барилга, байгууламж дотор тухайн бодисын үйлчлэлд өөрөө өртөхгүй байрлалыг сонгох ба гадна орчинд салхины чиглэл дагуу цацах, гранат хэлбэрээр шидэх, буудлагын хэрэгслээр буудах
6.	-Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүрийг 1-1.5 метрийн зайд хэрэглэж...	-Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийг 1-1.5 метрийн зайд хэрэглэж...		Нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчийг 1-1.5 метрийн зайд хэрэглэж...
Дөрөв. Резинэн, хуванцар сумтай буу хэрэглэх				
7.	-Резинэн ба хуванцар сумтай бууг хүний биеийн цээж, нуруу, гар, хөл, гуяны хэсэгт хэрэглэх бөгөөд нүүр, толгой /ил харагдах хэсэг/-н хэсэгт хэрэглэхийг хориглоно.	-Резинэн, хуванцар сумтай буу хэрэглэхэд дараахь зүйлийг анхаарна: 3.11.1.хуульд заасан үндэслэлээр резинэн, хуванцар	-Резин болон хуванцар сумтай бууг хэрэглэхдээ үйлдвэрлэгчийн зааврыг баримтлах ... ;	-Цагдаагийн алба хаагч резинэн, хуванцар сумтай бууг ...хэрэглэхдээ үйлдвэрлэгчийн зааврыг баримтлах

		сумтай ... бууг хэрэглэх үйлдвэрлэгчийн зааврыг баримтлах		
Зургаа. Бусад тусгай хэрэгсэл хэрэглэх				
8.	-Улсын хил хамгаалалтад орчин үеийн тусгай хэрэгслийг шинээр ашиглах тохиолдолд энэхүү зааварт нэмэлт өөрчлөлт оруулж, хэрэглэнэ.	Байхгүй	Байхгүй	Байхгүй

Хүснэгт 3. Агентлаг, байгууллагуудын алба хаагч заавар, журмуудын нэршил болон нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрхэн хэрэглэх талаарх холбогдох заалтын харьцуулалт

Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх эрхийг нийт 15 субъектэд тус тусын хууль тогтоомжоор олгосон байдаг. Холбогдох хуульд хэрэглэх эрх, үүрэг, хориглох тохиолдлыг тусгаж, хэрэглэх арга, анхаарах зүйл буюу техник, технологи, арга зүй, тактикийн шинжтэй хэм хэмжээг журамласан эрх зүйн актаар зохицуулжээ. Холбогдох эрх зүйн актыг 14 агентлаг, байгууллага нь заавар, 1 байгууллага нь журам гэж нэрлэжээ.

Дээрх харьцуулалтад цагдаа, дотоодын цэрэг, хил хамгаалах байгууллага заавар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх

байгууллага журам гэж харилцан адилгүй эрх зүйн актыг нэрлэсэн байна. Мөн “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”¹-ын 3.7.1.1-т “тэргүү буюу гарчиг нь агуулгаа бүрэн илэрхийлж чадахуйц тодорхой байна” гэж заасан бөгөөд “Дотоодын цэрэг чиг үүргээ хэрэгжүүлэхэд хэрэглэх тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай зориулалтын техникийг хэрэглэх” тухай хуульчилсан акт нь дүрэм, журам, заавар боловсруулахад тавигдах нийтлэг шаардлагыг хангахгүй, тэргүү буюу гарчиг нь дотоод агуулгаа бүрэн илэрхийлж чадахгүй байна. Харин “Хил хамгаалах байгууллагын алба

¹ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246 дугаар тогтоол

хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх” зааврын тэргүү буюу гарчиг нь дотоод агуулгаа бүрэн гүйцэд ханган илэрхийлж, чадаж байна гэж үзлээ.

Цагдаа болон хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч бороохойг хэрэглэх талаар заавар, журамдаа тусгагдсан дээрх хэм хэмжээнээс дотоодын цэргийн алба хаагчийн бороохой хэрэглэх талаар зааварт нь тусгасан хэм хэмжээ нь бодит нөхцөл байдал тохирсон, эрх зүйн баталгааг нь хангаж чадахуйц заалт болжээ. Харин хил хамгаалах байгууллагын алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулсан хуульчилсан актад бороохойгоор хувцастай болон нүцгэн биед чиглүүлж ороолгох маягаар цохих, хатгах, бамбай, бусад эд зүйлд цохиж, дуу чимээ гаргах, зэвсгийн чанартай эд зүйлээр довтолсон тохиолдолд хамгаалах зорилгоор өгзөгний маханд буюу дал хавсарч хэрэглэнэ гэж заасан нь тухайн хэрэгслийг хэрэглэх боломжгүй нөхцөл байдлыг оруулж, хэрэглэх зорилгыг хязгаарласан хэм хэмжээг тусгаж өгсөн гэж үзэж

байгаа. Зааварт зааснаар хэрэглэж, хэрэглэх зорилгодоо хүрэхгүйгээс үүсэх үр дагавар нь алба хаагчид эрсдэл үүсэх нөхцөл байдалд хүргэнэ гэж үзэж байна.

Мөн заавар, журмуудад цахилгаан гүйдлээр цохигчийн үелзэл, долгион, хүчдэл гэж янз бүрээр нэрлэжээ. Тухайн ойлголтыг Я.Цэвэлийн зохиосон “Монгол хэлний тайлбар толь” бүтээлд “хүчдэл вольтоор илэрхийлэгдэх цахилгаан тогийн хүчний хэмжээ”¹, “долгион физикийн орчин дотор үүсэх савлах хөдөлгөөн”² гэж тус тус тайлбарласан байх бөгөөд тухайн толь бичигт үелзэл гэх ойлголт байхгүй тул тайлбарлаагүй. Цагдаа, дотоодын цэрэг, хил хамгаалах байгууллагын зааварт ... цахилгаан гүйдлээр цохигчийг хүний биед хүчдэлийг (долгион, үелзэл) нэг газарт 5 секундээс, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын журамд 10 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар тооцож, харилцан адилгүй хугацааг заасан байна. Доктор Н.Ганбадрал цахилгаан гүйдлээр цохигчийн үйлчлэлийн талаар бүтээлдээ “хувь хүний биеийн эсэргүүцэл, ирж буй хүчдэл зэргээс болоод

¹ Цэвэл, Я. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966. 752 дахь тал

² Мөн тэнд 197 дахь тал

үйл ажиллагааны эцсийн үр дүн ч өөр өөр байна”¹ гэж дурджээ.

Цагдаа, дотоодын цэрэг, хил хамгаалах байгууллага тус тусын заавар, журамд цахилгаан гүйдлээр цохигч бууг хэрэглэхээр тусгаж, зохицуулалтыг хийсэн бөгөөд харин шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага цахилгаан гүйдлээр цохигч бууг хэрэглэхээр тусгаагүй байна.

Хил хамгаалах байгууллагын алба хаагчид тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх зааврын 3.9.2-т заахдаа цахилгаан гүйдлээр цохигч бууг хүний биед 4-5 метрийн зайд хэрэглэх бөгөөд нэг газар 3 секундээс илүүгүй хугацаагаар үйлчилж байхаар байрлалыг сольж, амьтанд 5 секундээс илүүгүй хугацаагаар хэрэглэнэ гэж тусгажээ. Энэ нь манай орон БНХАУ-аас цахилгаан гүйдлээр цохигч бууг импортоор оруулан ирж, төрийн тусгайлсан чиг үүрэг гүйцэтгэдэг байгууллагын албан хэрэгцээнд ашиглаж байгаа бөгөөд төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллага ашиглаж байгаа хэрэгслийнхээ хүчин чадал дээр тулгуурлан холбогдох эрх зүйн актад цахилгаан гүйдлээр цохигч

буугаар ямар зайд хэрхэн хэрэглэх талаар тодорхойлон тусгасан байна. Ингэж заавраар хэрэглэх хүчин чадал тактик, техникийн өгөгдөхүүнийг тодорхойлж, зохицуулах шаардлагагүй бөгөөд тухайн хэрэгсэл хаана, ямар газар үйлдвэрлэснээс шалтгаалан хүчин чадал, тактик техникийн өгөгдөхүүн нь өөр байдаг тул хууль, заавраар зохицуулах боломжгүй. Иймээс зарим тохиолдолд хэрэглэх тухайн тусгай хэрэгсэл нь зориулалт болон хүчин чадал, тактик техникийн өгөгдөхүүнээс шалтгаалан эрх зүйн актад тусгагдсан хэм хэмжээтэй зөрчилдөнө гэж бидний зүгээс үзэж байгаа юм.

Цагдаа, дотоодын цэрэг, ШШГБ заавар, журамдаа хориглосон хэм хэмжээг тусгаагүй байна. Харин хил хамгаалах байгууллага холбогдох зааврын 3.8.3-т “... хүний толгой, давсаг, бүсэлхий, бөөр, нэг газарт олон удаа цохих, гэмтэл, шарх үүсгэхийг хориглоно. Мөн зааврын 3.11.2 дахь хэсэгт алба хаагч резинэн ба хуванцар сумтай бууг хүний биеийн цээж, нуруу, гар, хөл, гуяны хэсэгт хэрэглэх бөгөөд нүүр, толгой /ил харагдах

¹ Ганбадрал,Н. Цахилгаан цочируулагч хэрэгсэл. УБ.,2008. 53 дахь тал

хэсэг/-н хэсэгт хэрэглэхийг хориглохоор тусгасан байх бөгөөд хуулиас гадна хуульчилсан актаар хориглосон хэм хэмжээг тусгасан байна.

Бусад тусгай хэрэгсэл хэрэглэх талаар Хил хамгаалах байгууллагын алба хаагчид тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх зааврын 3.12.1-т “Улсын хил хамгаалалтад орчин үеийн тусгай хэрэгслийг шинээр ашиглах тохиолдолд энэхүү зааварт нэмэлт өөрчлөлт оруулж, хэрэглэнэ”¹ гэж заажээ. Цагдаа, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нэг бүрийн бусад тусгай хэрэгслийг хэрэглэх талаар заавар, журмуудад нэг ч заалт тусгагдаагүй бөгөөд энэ хэрэгсэлд ямар хэрэгслийг хамааруулж, хэрэглэх нь ойлгомжгүй байна.

Дүгнэлт. Хууль тогтоомжид зарим тусгай хэрэгсэл нь аль төрөл, ангилалд хамаарах нь тодорхой бус ойлгомжгүй байна.

Монгол Улсын хилийн тухай хуульд хилчин нэг бүрийн тусгай хэрэгслийг хэрэглэх тохиолдол тодорхой бус, ерөнхий тусгасан. Хуулиар нэг бүрийн

тусгай хэрэгслийг хэрэглэх, хориглох тохиолдлыг тусгаж, эрх олгосон, хориглосон хэм хэмжээг дахин заавраар зохицуулж, тусгасан нь хууль цаазын дээд хүчин чадал, шатлан захирах шинж алдагдсан байна.

Зааврын зарим хэм хэмжээ нь хуульд тусгасан нийтлэг шаардлагад нийцэхгүй, хилчин үүрэг гүйцэтгэх үед нэг бүрийн тусгай хэрэгслийн зарим төрлийн төрлийн хэрэгслийг хэрэглэх боломжгүй нөхцөл байдлыг тусгаж, хэрэглэх эрхийг нь бүрэн хязгаарлажээ. Мөн “Хил хамгаалах байгууллагын алба хаагч тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэглэх заавар”-т нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхэд анхаарах болон арга зүйн шинжтэй хэм хэмжээг тусгасан боловч, заасан болон үүрэг болгосон, хориглосон хэм хэмжээтэй хамтад нь тусгасан байна. Иймээс эрх олгож, үүрэг болгосон, хориглосон хэм хэмжээг хуулиар зохицуулах, иргэний эрх эрх чөлөөг хангахад чиглэгдсэн зааварчилсан хэм хэмжээг заавраар баталгаажуулж, алба хаагчийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн техник,

¹ Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/160 дугаар тушаал

технологийн болон арга зүй буюу тактикийн шинжтэй хэм хэмжээг Хил хамгаалах байгууллагын дарга эрх хэмжээний хүрээнд эрх зүйн актыг боловсруулж, баталгаажуулж, стандартчилах нь шаардлагатай гэж үзэж байна. Түүнчлэн хилийн аюулгүй, халдашгүй дархан байдлыг хамгаалахын зэрэгцээ алба хаагчдын хувийн аюулгүй байдал, эрх зүйн баталгааг сайтар хангахын тулд нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль эрх зүйн актын холбогдох зарим зүйл, хэсэг, заалтад нэмэлт өөрчлөлт оруулж, боловсронгуй болгох шаардлагатай байгаа судалгаагаа нотоллоо.

Санал. Дээрх дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Монгол Улсын хилийн тухай хуулийн холбогдох/Хүч хэрэглэх/ зүйл, заалт, хэсэгтэй, холбогдох хуульчилсан актын зарим хэм хэмжээг нягтлан тулгаж, зөрүүтэй зохицуулалтыг гаргаж ирэх

2. Эрх зүйн орчин ижил төстэй улс орон болон өөрийн орны хууль сахиулах болон төрийн цэргийн байгууллагад хэрэгжиж буй ижил төстэй эрх зүйн зохицуулалтыг харьцуулан

судалж, нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхтэй холбоотой заалтын зарим эрх зүйн хэм хэмжээний давуу болон сул талыг тодорхойлж, гаргах

3. Хууль, хуульчилсан актад байгаа үг хэллэг, нэр томъёог хэл зүйн хувьд, оновчтой тодорхойлон, холбогдох эрх зүйн актад тусгасан байдлыг өөрчлөх

4. Хил хамгаалах байгууллагын дарга өөрийн эрх хэмжээний хүрээнд хүч хэрэглэх аюулгүй байдлаа хангах стандарт боловсруулах замаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль тогтоомж, эрх зүйн акт

1. Эрүүгийн хууль. “Төрийн мэдээлэл сэтгүүл” дугаар №7. 2015 он.
2. Монгол Улсын хилийн тухай хууль. “Төрийн мэдээлэл сэтгүүл” дугаар №6. 2017 он.
3. Монгол Улсын ЗГ-ын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246 дугаар тогтоолоор баталсан
4. Хууль зүй, дотоод хэргийн сайдын “Хил

хамгаалах
байгууллагын алба
хаагч тусгай хэрэгсэл,
биеийн хүч хэрэглэх
заавар” батлах тухай
2017 оны 06 дугаар
сарын 09-ний өдрийн
А/160 дугаар тушаал

5. Хууль зүй, дотоод
хэргийн сайд Улсын
ерөнхий прокурорын
хамтран “Цагдаагийн
алба хаагч биеийн хүч,
тусгай хэрэгсэл, галт
зэвсэг хэрэглэх заавар”
батлах тухай 2017 оны
09 дүгээр сарын 06-ны
өдрийн А/102, А/224
дүгээр тушаалын
хавсралт
6. Хууль зүй, дотоод
хэргийн сайдын
“Дотоодын цэрэг чиг
үүргээ хэрэгжүүлэхэд
хэрэглэх тусгай
хэрэгсэл, галт зэвсэг,
тусгай зориулалтын
техникийг хэрэглэх
заавар” батлах тухай
2018 оны 04 дүгээр
сарын 03-ны өдрийн
А/57 дугаар тушаал
7. Хууль зүй, дотоод
хэргийн сайд, Улсын
ерөнхий прокурорын
хамтарсан “Шүүхийн
шийдвэр гүйцэтгэх

байгууллагын алба
хаагч биеийн хүч,
тусгай хэрэгсэл галт
зэвсэг хэрэглэх” журам
батлах тухай 2017 оны
10 дугаар сарын 18-ны
өдрийн А/260, А/112
дугаар тушаал

8. Хил хамгаалах ерөнхий
газрын даргын 2019
оны 02 дугаар сарын
27-ны өдрийн А/09
дүгээр тушаал

Гурав. Ном, сурах бичиг, гарын авлага

9. Я.Цэвэл. Монгол
хэлний товч тайлбар
толь. 1966 он УБ хот
10. Ч.Нямсүрэн. Эрх зүйн
ерөнхий онол. 2017 он
УБ хот.
11. Н.Ганбадрал.
Цахилгаан цочруулагч
хэрэгсэл. 2008 он УБ
хот

Дөрөв. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил

12. С.Нямжав.
“Цагдаагийн алба хаагч
нэг бүрийн тусгай
хэрэгсэл хэрэглэх эрх
зүйн зохицуулалтад
хийсэн шинжилгээ”
илтгэл. 2024 он УБ хот

Тав. Цахим эх
сурвалжууд

13. <https://www.ojp.gov>.

Татаж үзсэн:

2023.11.10. “Less Lethal

Weapon Effectiveness,
Use of Force, and
Suspect & Officer
Injuries” 5 жилийн дүн
шинжилгээ